



**МОНГОЛ УЛСЫН
ХУУЛЬ ЗҮЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26-75-33, E-mail: foreign@moj.gov.mn,
http://www.moj.gov.mn

2015.01.29 № 1/254

танай _____-ны № _____-г

Хариу өгөх тухай

Танаас ирүүлсэн Хууль зүйн яам болон Цагдаагийн ерөнхий газрын мөрдөн байцаах асуудал хариуцсан байгууллагын албан контор, Хууль сахиулах байгууллагын албан контор, хууль сахиулах байгууллагын цахим мэдээлэл болон иргэдэд хууль зүйн үйлчилгээ үзүүлэх төвийн зориулалтаар баригдаж байгаа барилгын ажлын явц, цаашид авах арга хэмжээний талаарх мэдээлэл ирүүлэх тухай хүсэлттэй танилцлаа.

Хууль зүйн сайдын 2014 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн А/233 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг нь Хууль зүйн яам болон мөрдөн байцаах газрын албан конторын барилгыг клиник эмнэлэг болгох нөхцөлийг судалж байна.


Ажлын хэсэг нь барилгын төсөв хөрөнгийн зөрүү болон клиник эмнэлэг болгох нөхцөлийг судалж шаардлагатай тоног төхөөрөмжүүдийн судалгааг гаргаж урьдчилсан байдлаар хөрөнгийн тооцоог гаргаад байна.

1. А блокийн барилгыг хуучин зургийн дагуу эмнэлэг болгоход 136,9 метр куб өрлөг буулгаж эргүүлэн 1407 метр квадрат хамар хана өрж дагалдах шавардлага заслалын ажлыг хийж, 7 дугаар давхарт төлөвлөгдсөн нөөц, ус хангамжийн системээс бусад ажлыг бүрэн хийж гүйцэтгэхэд 305,3 сая төгрөгийн хөрөнгө,

2. Б блокийн барилгыг хуучин зургийн дагуу эмнэлгийн байдлаар болгоход 380,8 метр куб өрлөг буулгаж эргүүлэн 8382 метр квадрат хамар хана өрж дагалдах шавардлага заслалын ажлыг хийж салхивчийн системийг өөрчлөн хэсэгчлэн засаж цэвэр усан хангамж ариутгах татуургын ажил болон эмнэлгийн зориулалттай цахилгаан шат суурилуулах ажлуудыг хийж гүйцэтгэхэд 4,1 тэрбум төгрөгийн хөрөнгө шаардлагатай буюу барилгыг эмнэлгийн зориулалтаар бүрэн дуусгахад 4,4 тэрбум төгрөгийн хөрөнгө,

Эмнэлгийн тоног төхөөрөмж болон техник хэрэгслийн хангалтад 5,6 тэрбум төгрөг, 240 ортой клиник эмнэлгийн орон тоо, ашиглалтын зардалд 2,1 тэрбум төгрөг буюу клиник эмнэлгийн барилгыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулахад нийт 12,0 тэр бум төгрөгийн хөрөнгө зайлшгүй шаардлагатай байна.

САЙД



Д. ДОРЛИГЖАВ

C:\Documents\said.A-4 2015.doc

08 0255